



**“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ”
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2025-2028 ОН)**

Төлөвлөгөө баталсан:

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД



Төсвийн Ерөнхийлөн захирагч

Ц.БААТАРХҮҮ

Төлөвлөгөө боловсруулсан:

“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УТҮГ
ЗАХИРАЛ



Төсвийн шууд захирагч

М.БАТТУЛГА

АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл	3
2. Мандатын шинжилгээ	5
3. Орчны шинжилгээ	12
4. Алсын хараа	16
5. Эрхэм зорилго	16
6. Стратегийн зорилго	16
7. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги	19
8. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал	26
9. Хавсралт	27

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

“Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь Монгол Улсад цахим засаглалыг хөгжүүлэх зорилго бүхий “Цахим монгол”, “Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох” үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 183 дугаар тогтоолоор байгуулагдсан.

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай /Шинэчилсэн найруулга/, Харилцаа холбооны тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоол болон эдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам зэрэг эрх зүйн баримт бичгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын стратегийн төлөвлөгөөг боловсруулав.

Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газрын 2024-2028 онд баримтлах стратегийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг гаргахад энэ төлөвлөгөөний зорилго оршино.

1.1 БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Эрх зүйн байдал:

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: 7.5.8. Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, уян болон хатуу дэд бүтцийг хөгжүүлнэ.

“Цахим үндэстэн” баримтлах чиглэлийн 1.5. Дата төвийн найдвартай ажиллагаа, багтаамжийг нэмэгдүүлнэ.”, -1.5.2, 1.5.3, “2.1. Төрийн үйлчилгээний процессыг оновчилно.”, Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль: “33.2.Суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, түүний нөөцийг Үндэсний дата төвд хадгална.”, “18.10.Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”.

Чиг үүрэг:

Үндэсний дата төв нь төрийн цахимжилтийн суурь дэд бүтцийг бий болгож, түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах чиг үүрэг бүхий Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага юм.

Үндсэн болон дэмжих системүүд, суурь болон төрөлжсөн мэдээллийн сангууд Үндэсний дата төвд байршин ажиллаж байна. Үүнд:

Үндсэн систем:

- Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд;

Дэмжих систем:

- Танилт, нэвтрэлтийн систем;
- Нийтийн түлхүүрийн дэд бүтэц;
- Албан бичиг солилцооны дундын систем;
- Мэдээлэл солилцооны бүртгэлийн систем;
- Мэдэгдэл хүргэх систем;
- Төрийн үйлчилгээний нэгдсэн систем;

ДАН системд бүртгэлтэй Монгол Улсын иргэдийн тоо 2,2 саяд хүрч, ХУР системээр 59,8 сая удаагийн сервис дамжиж, И-монголиа системээс 61 сая удаагийн үйлчилгээ авсан нь үндсэн болон дэмжих системүүдийн хэрэглээ, ач холбогдол өндөр хэмжээнд хүрч, Монгол Улсын иргэдийн өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болсныг харуулж байна.

Монгол Улсын үндэсний цахим мэдээлэл, нийтийн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, дэд бүтцийн бэлэн байдлыг хангах гол чиг үүргийн хүрээнд Үндэсний дата төвийн үйл ажиллагааг гамшиг ослын үед нөөцөөс сэргээн ажиллах, нөөц төвийн байгууламжийг Дархан-Уул аймагт ашиглалтад оруулсан байна.

“Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь Монгол Улсын нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, бэлэн байдлыг хангах, түүнд тулгуурлан иргэн, байгууллагад үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.2 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА:

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Нийтийн мэдээллийн ил, тод байдлын тухай хуульд заасны дагуу Үндэсний дата төвд байршиж буй суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, түүний нөөц, байгууллагын мэдээллийн сан, мэдээлэл хариуцагчийн системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, улмаар төр, хувийн хэвшлийн байгууллагад үйлчилгээ үзүүлж дэвшилтэт технологи, салбарын чиг хандлагад суурилсан бодлого төлөвлөлтийг тодорхойлон гаргаж, түүнд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах хэрэгцээ шаардлага бий болоод байна.

Монгол Улсын Нийтийн мэдээллийн ил, тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны “Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ” гэсэн 2.4 дүгээр зорилтын хүрээнд “Тоон технологи ашиглан мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд чиглэсэн инновацын үйл ажиллагааг төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ”, 2.6 дугаар зорилтын хүрээнд “Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, “Хиймэл оюун ухаан ба ирээдүй” хөтөлбөр

хэрэгжүүлнэ”, 5.3 дугаар зорилтын хүрээнд “Цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн технологийн салбарын стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж, батална”, “Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно.”, “Цахим төлбөр тооцооны системийг төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн системтэй холбоно”, “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд мэдээлэл, харилцаа холбооны дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоог дэмжиж хэрэгжүүлнэ”, “Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үүлэн тооцооллын дэд бүтцийг өргөтгөж хөгжүүлнэ.”, “Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, хүнд суртал, авлига үүсэх эрсдэлээс хамгаална.” гэх Монгол Улсын хэмжээнд салбар бүрд хэрэгжих, Монгол Улсын иргэн бүрд хүрч үйлчлэх цахимжилтийн суурь дэд бүтэц, бэлэн байдлыг хангах замаар эдгээр үйл ажиллагаануудыг дэмжин ажиллах, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-д заасан үндэслэлээр Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газрын стратегийн төлөвлөгөөг боловсрууллаа.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/34 дугаар тушаалаар батлагдсан дүрэмд зааснаар “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ашиглалтын бэлэн байдал, уялдаа холбоог хангах, сайжруулах,
2. Нийтийн мэдээллийн санг зориулалтын нөхцөлд хадгалах, хүртээмжтэй байлгах, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах,
3. Иргэн, байгууллагад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах,
4. Үйлчилгээ авч буй иргэн, төрийн болон бусад байгууллагад кибер аюулгүй байдлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, халдлага, довтолгооны эсрэг хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх,
5. Интернетийн дотоод харилцан холболтын ашиглалт, үйлчилгээг хариуцах, харилцан холболтын төхөөрөмжөөр дамжиж буй халдлага, будилааны талаар анхааруулга өгөх,
6. Нийтийн мэдээллийн бүтцийн хүрээнд төрийн болон бусад байгууллагад үйлчилгээ үзүүлэх болно.

Мөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилго бүхий “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуульд зааснаар “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. Үндсэн системээр мэдээлэл солилцох холболт үүсгэх,
2. Үндсэн системд холбогдох хуулийн этгээдийн мэдээллийн системд тавигдах техникийн нөхцөл, шаардлагыг боловсруулах,
3. Үндсэн болон дэмжих системийн үйлдлийн бүртгэл үүсгэх, хадгалах, хамгаалах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах.

Мөн хуулийн 33.2 -д “Суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, түүний нөөцийг Үндэсний дата төвд хадгална.”, 33.3 -д “Байгууллагын мэдээллийн сангийн нөөцийг Үндэсний дата төвд хадгалж болно.”, 33.4 -д “Мэдээлэл хариуцагчийн системийг Үндэсний дата төвд байршуулж болно.” гэж тус тус тусгагдсан.

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.1.14-т зааснаар “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь “Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага” -д хамаардаг тул тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 19.2.1.кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам батлах;
- 19.2.2.кибер халдлага, зөрчлийн үед дагаж мөрдөх төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх;
- 19.2.3.мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар стандартыг нэвтрүүлэх;
- 19.2.4.кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хариуцсан нэгж, эсхүл албан тушаалтантай байх;
- 19.2.5.кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг жил тутамд, эсхүл мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний өөрчлөлт хийгдэх бүрд хэсэгчлэн, эрх бүхий байгууллагын шаардсанаар тухай бүр хийлгэж, гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 19.2.6.мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хоёр жил тутамд хийлгэх;
- 19.2.7.мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай удирдлага, зохион байгуулалтын болон техникийн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- 19.2.8.кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, бүртгэх, таслан зогсоох мэдээллийн системтэй байх;
- 19.2.9.мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний үйлдлийн бүртгэлийг кибер аюулгүй байдлын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалах;
- 19.2.10.кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний болон мэдээллийн аюулгүй байдлын аудитын тайланг хүлээн авснаас хойш нэг сарын дотор кибер халдлага, зөрчилтэй тэмцэх холбогдох төвд хүргүүлэх;
- 19.2.11.эрх бүхий байгууллагаас хүргүүлсэн зөвлөмж, шаардлагыг биелүүлэх, илэрсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;
- 19.2.12.гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээдээр кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэх тохиолдолд тагнуулын байгууллагаас санал авах;

19.2.13.хариуцсан мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн, найдвартай, тасралтгүй байдлыг хангах, гэмтэл саатлын үед сэргээн ажиллуулах төлөвлөгөөтэй байх;

19.2.14.кибер халдлага, зөрчлийн улмаас мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, тасралтгүй үйл ажиллагааг хангах боломжгүй болсон даруйд энэ талаар кибер халдлага, зөрчилтэй тэмцэх холбогдох төвд мэдэгдэх;

19.2.15.төлөвлөгөөт үзлэг шалгалт, өөрийн дэд бүтцээс гаднах сүлжээ, системд гарсан гэмтэл, саатал, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас дэд бүтцийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах боломжгүй бол энэ талаар кибер халдлага, зөрчилтэй тэмцэх холбогдох төв, хэрэглэгчид даруй мэдэгдэх.

“Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт хууль тогтоомжоор олгосон чиг үүргийн хүрээнд мандатын шинжилгээг хийж, дор дурдсан хүснэгтээр тодорхойлов.

Хүснэгт №1. Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн тоо		27	
Үүнээс:	Тухайн салбарын болон байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж	1.	Харилцаа холбооны тухай хууль
		2.	Цахим гарын үсгийн тухай хууль
		3.	Кибер аюулгүй байдлын тухай хууль
		4.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
		5.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
		6.	Төрийн болон албаны нууцын тухай хууль
		7.	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 06 дугаар сарын 24-ний 183 дугаар тогтоол “Үндэсний дата төв байгуулах тухай”
		8.	Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 04-ний 101 дүгээр тогтоол “Цахим засаг үндэсний хөтөлбөр батлах тухай”
		9.	Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 01-ний 146 дугаар тогтоол “Төрийн байгууллагын цахим мэдээллийн санг Үндэсний дата төв УТҮГ-т шилжүүлэн байршуулах тухай
		10.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 21-ний 153 дугаар тогтоол “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалтад нэмэлт оруулах тухай”
		11.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 49 дүгээр хуралдааны тэмдэглэлд “Үндэсний дата төвийн үйл ажиллагаанд үүлэн систем нэвтрүүлэх”

		12. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний 196 дугаар тогтоол “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам батлах тухай”
		13. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/34 дүгээр тушаал Үндэсний дата төв УТҮГ-ын дүрэм батлах тухай
		14. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/35 дугаар тушаал Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам
	Нийтлэг мөрддөг хууль тогтоомж	15. Төсвийн тухай хууль
		16. Шилэн дансны хууль
		17. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
		18. Хөдөлмөрийн тухай хууль
		19. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль
		20. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
		21. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
		22. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
		23. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
		24. Иргэний хууль
		25. Авлигын эсрэг хууль
		26. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
		27. Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам

ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ:

МОНГОЛ УЛСЫН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ, ТҮҮНД ТУЛГУУРЛАН ИРГЭН, БАЙГУУЛЛАГАД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

Үндсэн чиг үүрэг		Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1.	Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ашиглалтын бэлэн байдал, уялдаа холбоог хангах, сайжруулах	Инновац, дэвшилтэт техник, технологид суурилсан эрчим хүчний хэмнэлттэй, олон улсын стандартад нийцсэн дэд бүтцийг бий болгоно.	
		Олон Улсын дата төвийн түвшин “TIERIII” - ийг хангаж, “Uptime” олон улсын байгууллагаар баталгаажуулах, Дэд бүтцийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг үнэлэх, хэмжих, хяналт тавих /KPI/ тодорхойлж, хэрэгжүүлэх, Серверийн өрөөний зохион байгуулалтыг /Containment/ шийдлээр шинэчлэх,	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

		цахилгаан хангамжийн үргүй зардлыг бууруулах, /TIA942, TIA569/ стандартад нийцүүлж кабель менежментийг хийж хэрэгжүүлэх, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Дата төв байгуулах, Сэлгэн ажиллах “НА” төвийг бий болгох, Дотоод хэрэглээний цахилгаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр хангаж, гэрэл цахилгааны автоматжуулсан хэмнэлтийн систем нэвтрүүлэх, Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хангамжийн дизель генераторыг шинэчилж, ашиглалтад оруулах, Дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах,	
		<i>Нийтийн мэдээллийн дэд бүтцийг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн оновчтой зохион байгуулна.</i>	
		Инновац, дэвшилтэт техник, технологид суурилсан олон улсын стандартад нийцүүлэн сүлжээ, системийн архитектурыг шинэчлэх Их өгөгдлийг боловсруулж, хиймэл оюун ухааныг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх “Cloud GPU” суурь дэд бүтцийг бий болгох “Hybrid” болон “Multicloud” дэд бүтцийг бий болгож их өгөгдөл боловсруулах төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх Үүлэн тооцооллын хөгжүүлэлтийг дэмжиж хэрэглээг нэмэгдүүлнэ. Төрийн байгууллагын ашиглаж буй хатуу болон зөөлөн дэд бүтцийг үүлэн технологи руу үе шаттайгаар шилжүүлж, дэд бүтцийн болон хөрөнгө оруулалтын давхцалыг бууруулах “Data Center Automation” нэгдсэн системийг нэвтрүүлэх Үндсэн болон дэмжих системийн аюулгүй, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлаар хэрэглэгчийн хэрэгцээнд нийцүүлэн технологийн сайжруулалт, шинэчлэлтийг хийх Үндсэн болон дэмжих системийн үйлдлийн бүртгэл үүсгэх, хадгалах, хамгаалах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах Үндсэн системээр мэдээлэл солилцох холболт үүсгэх Систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

2.	Нийтийн мэдээллийн санг зориулалтын нөхцөлд хадгалах, хүртээмжтэй байлгах, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах	Нийтийн мэдээллийн сан, дэд бүтцийн хэвийн, тасралтгүй, аюулгүй байдлыг хангасан шинэчлэлийг хэрэгжүүлнэ. МАБУТ/ISO 27001:2022 Олон улсын аюулгүй байдлын стандарт хангасан үйлчилгээг үзүүлэх Онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий дата төвд кибер аюулгүй байдлын шаардлагыг хэрэгжүүлэх Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг шуурхай тодорхойлж, шийдвэрлэх хяналтын системийг нэвтрүүлэх Хиймэл оюун ухаан (AI) болон машин сургалтыг (ML) кибер аюулгүй байдал, үүлэн тооцооллын аюулгүй байдлыг хангахад ашиглан автоматжуулсан хариу арга хэмжээ авах систем, хамгаалалтыг бий болгох Төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах Систем, сүлжээний аюулгүй байдлыг хангах Нийтийн мэдээллийн сангийн хүртээмжтэй байдлыг хангахад хиймэл оюун ухааныг ашиглах талаар судалгаа шинжилгээ хийж, нэвтрүүлэх	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Тагнуулын ерөнхий газар
3.	Иргэн, байгууллагад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах	Нийтийн мэдээллийн дэд бүтцэд суурилсан үйлчилгээг хүний нөөцийн тогтвортой хөгжил, удирдлага зохион байгуулалтын хүрээнд үзүүлнэ. Цахим хуудсаар дамжуулан мэдээллийн технологийн холбогдох заавар, зөвлөгөөг нийтлэх Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд зориулсан өдөрлөг, сургалтыг зохион байгуулах Иргэн, байгууллагад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн байгууллагууд
4.	Үйлчилгээ авч буй иргэн, төрийн болон бусад байгууллагад кибер аюулгүй байдлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, халдлага, довтолгооны	Нийтийн мэдээллийн сан, дэд бүтцийн хэвийн, тасралтгүй, аюулгүй байдлыг хангасан шинэчлэлийг хэрэгжүүлнэ. Дата төвийн кибер аюулгүй байдлын уян хатан байдлыг сайжруулж, халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадамжийг бүрдүүлэх Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний болон мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх, хэрэгжилтийг	Төрийн байгууллагууд

	эсрэг хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх	хангах, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвд тайлагнах Кибер халдлага, зөрчлийн талаар гадаад болон Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага солилцох Кибер аюулгүй байдлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зүй, зөвлөгөөг хэрэглэгч, байгууллагуудад түгээх	
5.	Интернетийн дотоод харилцан холболтын ашиглалт, үйлчилгээг хариуцах, харилцан холболтын төхөөрөмжөөр дамжиж буй халдлага, будилааны талаар анхааруулга өгөх	Нийтийн мэдээллийн сан, дэд бүтцийн хэвийн, тасралтгүй, аюулгүй байдлыг хангасан шинэчлэлийг хэрэгжүүлнэ.	
		Монголын интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх Интернэтийн дотоод харилцан холболтын төхөөрөмжөөр дамжиж буй халдлага будилааны талаар анхааруулга өгөх Мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний үйлдлийн бүртгэлийг кибер аюулгүй байдлын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалах Интернетийн дотоод харилцан холболтыг сайжруулах, аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
6.	Нийтийн мэдээллийн бүтцийн хүрээнд төрийн болон бусад байгууллагад үйлчилгээ үзүүлэх, захиргаа удирдлагаар хангах	Нийтийн мэдээллийн дэд бүтцэд суурилсан үйлчилгээг хүний нөөцийн тогтвортой хөгжил, удирдлага зохион байгуулалтын хүрээнд үзүүлнэ.	
		Төрийн болон бусад байгууллагад мэдээлэл солилцооны үйлчилгээ үзүүлэх Мэдээллийн технологид суурилсан үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх замаар төрийн цахимжилтад дэмжлэг үзүүлж, хэрэглэгчийн үйлчилгээний сэтгэл ханамжийг дээшлүүлэх Үйлчилгээний системийг автоматжуулж, тоон гарын үсгийн хэрэглээнд тулгуурласан цаасгүй технологийг нэвтрүүлэх Байгууллагын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 Олон улсын стандарт нэвтрүүлэх, хэрэгжүүлэх Олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж, сайн туршлагыг нэвтрүүлэх	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн байгууллагууд

	Байгууллагын стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах, дүгнүүлэх Дотоод үйл ажиллагаа болон газар, хэлтсийн уялдаа холбоог сайжруулах Байгууллагад мөрдөгдөх дотоод журам, заавар, дэг боловсруулах, шинэчлэн сайжруулах, хэрэгжилтийг хангуулах Албан хаагчдыг мэргэшүүлэх, сургалтад хамруулах, нийгмийн баталгааг нь хангах	
--	---	--

ГУРАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим засаг”, 2019 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн мэдээллийн систем, мэдээллийн санг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, Төрийн цахим шилжилт, төрийн цахим үйлчилгээ, цахим системийн суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангах замаар төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, МУЗГ -ын 2022 оны 49 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгагдсаны дагуу үйл ажиллагаандаа “үүлэн систем” нэвтрүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн системийг “үүлэн систем” -д байршуулах, мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO:27001 стандарт хэрэгжүүлэлтийн болон дотоод аудиторын сертификаттай сургалтад хамруулж, хүний нөөцийн бэлэн байдлыг ханган, баримт бичгүүдийг боловсруулан баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, олон улсын баталгаажуулалтын байгууллага болох Франц Улсын “Афнор групп”-ын ISO:27001 стандартын сертификатаар Олон Улсад үйл ажиллагаагаа баталгаажуулж ажиллалаа.

Үндсэн чиг үүргийн хүрээнд “ХУР” Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем, “ДАН” Танилт, нэвтрэлтийн системд холбогдсон төрийн байгууллага болон хуулийн этгээдэд хууль, журамтай холбоотой зөвлөмж, мэдээллийг тогтмол өгч ажилласан. Нийтийн мэдээллийн ил, тод байдлын тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулан цахим хуудсаараа дамжуулан холбогдох мэдээллүүдийг тогтмол нийтэлж байна.

Танилт, нэвтрэлтийн “sso.gov.mn” систем нь 2024 оны байдлаар төрийн 79 байгууллага, хувийн 214 байгууллага нийт 293 байгууллагын системд холбогдсон ба бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо 2,110,324 нийт 60,531,424 удаа нэвтрэлт хийж, 137,892,797 удаа үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн хугацаанд шинээр 158,439 иргэн бүртгүүлж, 24,510,699 удаа нэвтрэлт хийж, 60,197,195 удаа үйлчилгээ үзүүлжээ.

“ХУР” төрийн мэдээлэл солилцооны үндсэн системд нийт 514 байгууллага холбогдож, 773 веб сервис хөгжүүлэгдсэн, нийт 2,910,670,929 удаа амжилттай үйлчилгээ авсан байна. 2024 онд “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системд 123 сервис нэмж хөгжүүлжээ.

“Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь хууль тогтоомжоор хүлээлгэсэн үндсэн чиг үүргээ өөрийн хүчин чадал, чадавхын хүрээнд хэрэгжүүлж

байгаа ч мэдээллийн технологи хурдтай хөгжиж буй өнөө үед Монгол Улсын нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, бэлэн байдлыг хангах, түүнд тулгуурлан иргэн, байгууллагад үйлчилгээ үзүүлэхэд дараах хүндрэл бэрхшээл тулгарсаар байна. Үүнд:

1. Хүний нөөцийн стратеги

“Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь албан хаагчдыг байнга сурах бололцоогоор хангаж, сургалт хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлдэг хэдий ч бусад байгууллага ялангуяа мэдээллийн технологийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагуудтай өрсөлдөх чадвар санхүүгийн хувьд бэрхшээлтэй тул төдий хэмжээнд хүрч чадахгүй байгаа нь хүний нөөцийн хомсдол бий болгох, энэхүү эрсдэлээс зайлсхийх шаардлагатай тулгарч байна. Байгууллага нь улсын төсвөөр санхүүждэг учраас тухай бүр нь цалин хангамжийг нэмэгдүүлэх боломж хомс юм. Энэ нь тус төвийн цалин хангамжид тохирсон, мэдлэг, чадвартай боловсон хүчин, хүний нөөцийг бүрдүүлэхэд эрсдэлтэй тул хүний нөөцийн стратеги баримтлан ажиллах зайлшгүй шаардлагатай тулгарч байна.

2. Төсөв санхүүжилт

Мэдээллийн технологи асар хурдтай хөгжиж байгаа өнөө үед мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, программ хангамж хурдтай шинэчлэгдэн өөрчлөгдөж сайжирч байна. Үүнтэй зэрэг хөгжих боломж төсөв санхүүгээс болж хязгаарлагдмал байна. Тус төвийн үндсэн чиг үүрэг болох нийтийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангахад тогтмол шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжуудыг авч ашиглаж байх шаардлагатай байдаг. Мөн “Үндэсний дата төв” УТҮГ-аас 2021 онд хийгдсэн судалгаагаар Төрийн цахим үйлчилгээ цахим системийн 90 гаруй хувь нь ҮДТ-ийн дэд бүтцээс шууд хамааралтай ажиллаж байна гэсэн судалгаа гарсан. Тэр утгаараа 2017 оноос 2022 оны хооронд ухаалаг засаг төслийн хүрээнд хийгдсэн 19,605,264,137 төгрөгийн хөрөнгө оруулалт нь ҮДТ-ийн дэд бүтцийг өргөтгөх замаар Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй, төрийн үйлчилгээний цахим системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, төрийн цахим шилжилтийг Олон Улсын түвшний жишгээр нэвтрүүлэхээр ажиллаж байна. Дээрх хөрөнгө оруулалтаар суурилуулагдсан тоног төхөөрөмж, программ хангамжийн ашиглалт үйлчилгээний хүрээнд ашиглалт, лиценз, хүний нөөц, цахилгаан дэд бүтцийн зардал төдий хэмжээгээр жил бүр өсөн нэмэгдэж байна.

3. Хууль эрх зүй

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Харилцаа холбооны тухай хуулиуд шинэчлэгдэн батлагдаж, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын чиг үүрэгт зохицуулалт бий болсон хэдий ч төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоход тэдгээрийн эрх үүргийг тодорхойлсон процессын нарийвчилсан зохицуулалт, үүрэг, хариуцлага хангалттай бус сайжруулах шаардлагатай байна.

4. Цахилгаан, эрчим хүчний хангамжийн асуудал

Монгол Улсын нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, бэлэн байдлыг хангах, түүнд тулгуурлан иргэн, байгууллагад үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь дата төвийн голлох үзүүлэлт болох цахилгаан, эрчим хүчний хангамжаас хараат бус байх нь чухал юм. Үндэсний Дата Төвийн нөөц цахилгаан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, өндөр ба нам хүчдэлийн цахилгаан хангамж болон хөргөлтийн төхөөрөмжийн тоноглол, дагалдах төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, дэд бүтцийн тоноглолын хяналт ашиглалт сайжруулах шаардлагатай юм. Олон Улсын “Uptime” байгууллагаар баталгаажуулалт хийлгэж, Дата төвийн “TIERIII” түвшинг хангах, Олон улсын стандартад нийцсэн дэд бүтцийг бий болгох нэн чухал үзүүлэлт юм.

5. Сэлгэн ажиллах дата төв

Олон улсад цахимжилт хурдацтай хөгжихийн хэрээр, цахим өгөгдөл мэдээллийн аюулгүй, бүрэн бүтэн, тасралтгүй байдал чухлаар тавигдах болсон. Үүний хүрээнд гамшиг ослын үед нөөцөөс сэргээх Нөөц дата төвийг барьж ашиглалтад оруулсан бол Олон улсын дата төвийн стандартад нийцүүлэн High availability буюу тасралтгүй ажиллагааг хангах шууд сэлгэн ажиллах дата төв зайлшгүй шаардлагатай юм.

Орчны шинжилгээний SWOT хүснэгт

Хүснэгт №2. Орчны шинжилгээний үр дүнг нэгтгэх “SWOT” шинжилгээ

ДОТООД ОРЧИН	
ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
- Нийтийн мэдээллийн санг хадгалах, хамгаалах зориулалттай дэд бүтэц бүхий дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон барилга байгууламжтай, - Мэдлэг боловсрол өндөр ур чадвартай хүний нөөцтэй, - Гамшиг ослын үед нөхөн сэргээх боломж бүхий нөөц төвтэй, - Ажилтан, албан хаагчид нь алсын хараа, эрхэм зорилго, зорилт, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй, - Бүтээгдэхүүн үйлчилгээ авч буй иргэд, төрийн болон бусад байгууллагын сэтгэл ханамжид илүү их анхаардаг.	- Мэргэжлийн зөвлөх /эксперт/ дутмаг, - Мэдээллийн технологийн техник тоног төхөөрөмж үргэлж шинэчлэгдэн сайжирч өөрчлөгдөж буйтай холбоотойгоор тухай бүр нь тоног төхөөрөмж шинэчлэх боломжгүй, - Ажилтнуудын мэдлэг боловсролын дээшлүүлэх талаар сургалтад байнга хамруулах боломжгүй, - Хүний нөөцийн тогтвортой байдал, хүний нөөцийн аюулгүй байдал, цалин хангамж хангалтгүй.
ГАДААД ОРЧИН	
БОЛОМЖ	ЭРСДЭЛ
- Хууль эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн, - Олон улсын стандарт, шаардлагад нийцсэн дэд бүтэц бүхий дата төвийн байгууламж улсын хэмжээнд дутмаг учраас бусад байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөл бололцоотой, - Мэдээллийн технологийн чиглэлээр гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжтой.	- Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагддаг, - Мэдээллийн технологийн тоног төхөөрөмж байнга шинэчлэгдэн сайжирч байдаг боловч тухай бүр хөрөнгө оруулалт хийх боломжгүй, - Төрөөс санхүүждэг учраас хүний нөөцийг сайжруулахад санхүүгийн боломж дутмаг. - Үйлчилгээний үнэ төлбөргүй байдлаас үүдэн нөөцийн зөв зохистой хэрэглээ, дэд бүтцийн бэлэн байдлыг хангахад эрсдэлтэй, үргүй зардал үүсгэдэг. - Төрийн байгууллагын хүний нөөц, ур чадвараас шалтгаалан үйлчилгээний кибер аюулгүй байдлын эрсдэлтэй. - Цахилгаан хангамжийн үндсэн эх үүсвэр дата төвийн ОУ -ын стандартын шаардлага хангахгүй.

ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА

ДИЖИТАЛ ӨСӨЛТИЙН МАНЛАЙЛАГЧ, ИННОВАЦЫГ ХӨГЖҮҮЛЭГЧ, ЦАХИМ ХӨГЖЛИЙН ТУЛГУУР ДЭЛХИЙН ЖИШИГТ НИЙЦСЭН БАЙГУУЛЛАГА БОЛНО.

ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН СУУРЬ ДЭД БҮТЦИЙГ БЭХЖҮҮЛЖ, ИХ ӨГӨГДЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ БОЛНО.

- ❖ АЮУЛГҮЙ,
- ❖ НАЙДВАРТАЙ,
- ❖ ҮР АШИГТАЙ,
- ❖ ИННОВАЦЛАГ

Үнэт зүйл:

- Чадварлаг баг, хамт олон
- Хэрэглэгч төвтэй харилцаа, хамтын хөгжил
- Хуулийн нийцэл, хэрэгжүүлэлт
- Хариуцлагатай байдал, тасралтгүй сайжруулалт
- Тогтвортой хөгжил, Инновацлаг сэтгэлгээ

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Инновац, хиймэл оюун ухаанд суурилсан, олон улсын стандартад нийцсэн өгөгдлийн засаглалын суурь дэд бүтцийг бий болгоно.

Төрийн цахимжилтын их өгөгдөл, хиймэл оюун ухаан, инновацийг шингээсэн, үүлэн технологи бүхий олон улсын стандартад нийцсэн суурь дэд бүтцийг бий болгоно.

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ:

Стратегийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1. ИННОВАЦ, ДЭВШИЛТЭТ ТЕХНИК, ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН ДЭД БҮТЦИЙГ БИЙ БОЛГОНО.

- 1.1 Олон Улсын дата төвийн түвшин “TIERIII” -ийг хангаж, “Uptime” олон улсын байгууллагаар баталгаажуулсан байна. /2026 он/
- 1.2 Дэд бүтцийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг үнэлэх, хэмжих, хяналт тавих /KPI/ тодорхойлж, хэрэгжүүлнэ. /2025 он/
- 1.3 Серверийн өрөөний зохион байгуулалтыг /Containment/ шийдлээр шинэчлэх, цахилгаан хангамжийн үргүй зардлыг бууруулна. /2026 он/

- 1.4 /TIA942, TIA569/ стандартад нийцүүлж кабель менежментийг хийж хэрэгжүүлнэ. /2026 он/
- 1.5 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Дата төв байгуулна. /2028 он/
- 1.6 Сэлгэн ажиллах “НА” төвийг бий болгоно. /2026 он/
- 1.7 Дотоод хэрэглээний цахилгаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр хангаж, гэрэл цахилгааны автоматжуулсан хэмнэлтийн систем нэвтрүүлнэ. /2026 он/
- 1.8 Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хангамжийн дизель генераторыг ашиглалтад оруулна. /2025 он/
- 2. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА.**
- 2.1 Инновац, дэвшилтэт техник, технологид суурилсан олон улсын стандартад нийцүүлэн сүлжээ, системийн архитектурыг шинэчилнэ. /2026 он/
- 2.2 Цахим системийн эх кодыг аюулгүй, найдвартай хадгалж, тасралтгүй нэгтгэх, түгээх, хөгжүүлэх, эх кодын аюулгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлсэн нэгдсэн дэд бүтцийг бий болгож төрийн байгууллагуудад эх кодын хувилбар удирдах систем "GITLAB" -ийн үйлчилгээг үзүүлнэ. /2025 он/
- 2.3 Их өгөгдлийг боловсруулж, хиймэл оюун ухааныг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх “Cloud GPU” суурьтай “Data Lake”, “Data Warehouse” дэд бүтцийг бий болгоно. /2027 он/
- 2.4 “Hybrid” болон “Multicloud” дэд бүтцийг бий болгож их өгөгдөл боловсруулах төрийн үйлчилгээнд нэвтрүүлнэ. /2028 он/
- 2.5 Үүлэн тооцооллын хөгжүүлэлтийг дэмжиж хэрэглээг нэмэгдүүлнэ. Төрийн байгууллагын ашиглаж буй хатуу болон зөөлөн дэд бүтцийг үүлэн технологи руу үе шаттайгаар шилжүүлж, дэд бүтцийн болон хөрөнгө оруулалтын давхцалыг бууруулна. /2026 он/
- 2.6 “Data Center Automation” нэгдсэн системийг нэвтрүүлнэ. /2027 он/
- 2.7 Үндсэн болон дэмжих системийг аюулгүй, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлаар хэрэглэгчийн хэрэгцээнд нийцүүлэн технологийн сайжруулалт, шинэчлэлтийг хийнэ. /2026 он/
- 2.8 Монгол Улсад дата серверийн эдийн засгийн хөгжлийг стратегийн түвшинд дэмжих, бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагаагаар манлайлан оролцох, энэ салбарын тэргүүлэгч байгууллага болох. /2025-2027 он/
- 2.9 Олон улсын шилдэг туршлага, технологийг нутагшуулах, хамтарсан төсөл, хөрөнгө оруулалтыг татах замаар гадаад хамтын ажиллагааг стратегийн түвшинд өргөжүүлэн хөгжүүлэх. /2025-2027 он/

3. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, ДЭД БҮТЦИЙН ХЭВИЙН, ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСАН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

- 3.1 МАБУТ/ISO 27001:2022 Олон улсын аюулгүй байдлын стандарт хангасан үйлчилгээг үзүүлнэ. /тогтмол/
- 3.2 Онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий дата төвд кибер аюулгүй байдлын шаардлагыг хэрэгжүүлнэ. /2025 он/
- 3.3 Дата төвийн кибер аюулгүй байдлын уян хатан байдлыг сайжруулж, халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадамжийг бүрдүүлнэ. /2026 он/
- 3.4 Интернэтийн дотоод харилцан холболтын төхөөрөмжөөр дамжиж буй халдлага будилааны талаар анхааруулга өгнө. /2026 он/
- 3.5 Хиймэл оюун ухаан (AI) болон машин сургалтыг (ML) кибер аюулгүй байдал, үүлэн тооцооллын аюулгүй байдлыг хангахад ашиглан автоматжуулсан хариу арга хэмжээ авах систем, хамгаалалтыг бий болгоно. /2026 он/

4. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛНЭ.

- 4.1 Мэдээллийн технологид суурилсан үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх замаар төрийн цахимжилтад дэмжлэг үзүүлж, хэрэглэгчийн үйлчилгээний сэтгэл ханамжийг дээшлүүлнэ. /2025 он/
- 4.2 Үйлчилгээний системийг автоматжуулж, тоон гарын үсгийн хэрэглээнд тулгуурласан цаасгүй технологийг нэвтрүүлнэ. /2025 он/
- 4.3 Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 Олон улсын стандартын шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлнэ. /2025 он/
- 4.4 Олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж, сайн туршлагыг нэвтрүүлнэ. /2027 он/
- 4.5 Хүний нөөцийн бэлэн байдлыг хангах, мэдлэг ур чадварт суурилсан тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлж, ажлын байрны эрсдэлийн үнэлгээг ажилтны үр дүнгийн урамшуулалд нийцүүлэн хэрэгжүүлнэ. /2026 он/
- 4.6 Дата төвийн цаашдын үйл ажиллагаа, технологийн дэвшлийг хангах зорилгоор мэргэжлийн, өндөр ур чадвартай хүний нөөцийг тасралтгүй бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх. /2025-2027 он/

Дэвшилтэт технологийг чадварлаг мэргэжилтний инновацлаг үйл ажиллагаатай хослуулах замаар цахим шилжилтийн дэд бүтэц, суурь хөгжлийг бэхжүүлнэ.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН

Хүснэгт №3. Стратегийн төлөвлөгөө

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүргийн нэр: МОНГОЛ УЛСЫН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ, ТҮҮНД ТУЛГУУРЛАН ИРГЭН, БАЙГУУЛЛАГАД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ					
Үндсэн чиг үүрэг 1: Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ашиглалтын бэлэн байдал, уялдаа холбоог хангах, сайжруулах					
Зорилт-1. Инновац, дэвшилтэт техник, технологид суурилсан эрчим хүчний хэмнэлттэй, олон улсын стандартад нийцсэн дэд бүтцийг бий болгоно.	Олон Улсын дата төвийн түвшин “TIERIII” -ийг хангаж, “Uptime” олон улсын байгууллагаар баталгаажуулах	Сертификатын баталгаажуулалтаар	0	1	Улсын төсөв
	Дэд бүтцийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг үнэлэх, хэмжих, хяналт тавих /KPI/ тодорхойлж, хэрэгжүүлэх	KPI хэрэгжсэн үр дүнгээр	0	1	Улсын төсөв
	Серверийн өрөөний зохион байгуулалтыг /Containment/ шийдлээр шинэчлэх, цахилгаан хангамжийн үргүй зардлыг бууруулах	Containment техникийн нөхцөл шаардлагын хэрэгжилтээр	0	1	Улсын төсөв
	/TIA942, TIA569/ стандартад нийцүүлж кабель менежментийг хийж хэрэгжүүлэх	Кабель менежмент нэвтрүүлсэн эсэх	0	1	Улсын төсөв
	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Дата төв байгуулах	Дата төв байгуулагдсан эсэх	0	1	Улсын төсөв
	Сэлгэн ажиллах НА төвийг бий болгох.	Сэлгэн ажиллах байгуулагдсан эсэх	0	1	Улсын төсөв

	Дотоод хэрэглээний цахилгаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчээр хангаж, гэрэл цахилгааны автоматжуулсан хэмнэлтийн систем нэвтрүүлэх	Систем бий болгосон эсэх	0	1	Улсын төсөв
	Эрчим хүчний хэмнэлттэй Цахилгаан хангамжийн дизель генераторыг шинэчилж, ашиглалтад оруулах	Дизель генератор ашиглалтад орсон эсэх	1	2	Улсын төсөв
	Дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах	Дэд бүтцийн хэвийн ажиллах нөхцөл бүрдсэн байна.	1	1	Улсын төсөв
Зорилт-2. Нийтийн мэдээллийн дэд бүтцийг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн оновчтой байгуулна.	Инновац, дэвшилтэт техник, технологид суурилсан олон улсын стандартад нийцүүлэн сүлжээ, системийн архитектурыг шинэчлэх	ОУ-ын стандартад нийцсэн сүлжээ, системийн архитектур хөгжүүлсэн эсэх	1	2	Улсын төсөв
	Их өгөгдлийг боловсруулж, хиймэл оюун ухааныг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх “Cloud GPU” суурь дэд бүтцийг бий болгох	Шаардлагатай суурь дэд бүтцийг бий болсон эсэх	0	1	Улсын төсөв
	“Hybrid” болон “Multicloud” дэд бүтцийг бий болгож их өгөгдөл боловсруулах төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх	Их өгөгдөл боловсруулах боломж бүхий дэд бүтэц бий болсон эсэх	0	1	Улсын төсөв
	Үүлэн тооцооллын хөгжүүлэлтийг дэмжиж хэрэглээг нэмэгдүүлнэ. Төрийн байгууллагын ашиглаж буй хатуу болон зөөлөн дэд бүтцийг үүлэн технологи руу үе шаттайгаар шилжүүлж, дэд бүтцийн болон хөрөнгө оруулалтын давхцалыг бууруулах	Үүлэн технологийн хэрэглээ нэмэгдсэн эсэх	1	2	Улсын төсөв

	"Data Center Automation" нэгдсэн системийг нэвтрүүлэх	Систем нэвтэрсэн эсэх	1	2	Улсын төсөв
	Үндсэн болон дэмжих системийн аюулгүй, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлаар хэрэглэгчийн хэрэгцээнд нийцүүлэн технологийн сайжруулалт, шинэчлэлтийг хийх	Технологийн сайжруулалт	1	2	Улсын төсөв
	Үндсэн болон дэмжих системийн үйлдлийн бүртгэл үүсгэх, хадгалах, хамгаалах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах	Бүртгэл үүсгэх, хадгалах, хамгаалах нөхцөл бүрдсэн эсэх	1	1	Улсын төсөв
	Үндсэн системээр мэдээлэл солилцох холболт үүсгэх	Холболт үүссэн тоо	500	700	Улсын төсөв
	Систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах	Систем, сүлжээний хэвийн ажиллах нөхцөл бүрдсэн эсэх	1	1	Улсын төсөв
Үндсэн чиг үүрэг 2: Нийтийн мэдээллийн санг зориулалтын нөхцөлд хадгалах, хүртээмжтэй байлгах, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах					
Зорилт-3. Нийтийн мэдээллийн сан, дэд бүтцийн хэвийн, тасралтгүй, аюулгүй байдлыг хангасан шинэчлэлийг хэрэгжүүлнэ.	МАБУТ/ISO 27001:2022 Олон улсын аюулгүй байдлын стандарт хангасан үйлчилгээг үзүүлэх	Стандартын баталгаажуулалт, хэрэгжүүлэлт	1	2	Улсын төсөв
	Онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий дата төвд кибер аюулгүй байдлын шаардлагыг хэрэгжүүлэх	Шаардлага хангасан байх	1	2	Улсын төсөв
	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг шуурхай тодорхойлж, шийдвэрлэх хяналтын системийг нэвтрүүлэх				


	Хиймэл оюун ухаан (AI) болон машин сургалтыг (ML) кибер аюулгүй байдал, үүлэн тооцооллын аюулгүй байдлыг хангахад ашиглан автоматжуулсан хариу арга хэмжээ авах систем, хамгаалалтыг бий болгох	Хариу арга хэмжээний систем, хамгаалалтыг бий болсон эсэх	0	1	Улсын төсөв
	Төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах	Аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдсэн эсэх	1	1	Улсын төсөв
	Систем, сүлжээний аюулгүй байдлыг хангах	Аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдсэн эсэх	1	1	Улсын төсөв
	Нийтийн мэдээллийн сангийн хүртээмжтэй байдлыг хангахад хиймэл оюун ухааныг ашиглах талаар судалгаа шинжилгээ хийж, нэвтрүүлэх	Судалгааны тоо	0	1	Улсын төсөв
Үндсэн чиг үүрэг 3: Иргэн, байгууллагад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах					
Зорилт-4. Нийтийн мэдээллийн дэд бүтцэд суурилсан үйлчилгээг хүний нөөцийн тогтвортой хөгжил, удирдлага зохион байгуулалтын хүрээнд үзүүлнэ.	Цахим хуудсаар дамжуулан мэдээллийн технологийн холбогдох заавар, зөвлөгөөг нийтлэх	Нийтэлсэн заавар зөвлөгөөний тоо	10	50	Улсын төсөв
	Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд зориулсан өдөрлөг, сургалтыг зохион байгуулах	Өдөрлөг сургалтын тоо	2	8	Улсын төсөв
	Иргэн, байгууллагад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх	Үзүүлсэн үйлчилгээний тоо	1	1	Улсын төсөв

Үндсэн чиг үүрэг 4: Үйлчилгээ авч буй иргэн, төрийн болон бусад байгууллагад кибер аюулгүй байдлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, халдлага, довтолгооны эсрэг хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх					
Зорилт-3. Нийтийн мэдээллийн сан, дэд бүтцийн хэвийн, тасралтгүй, аюулгүй байдлыг хангасан шинэчлэлийг хэрэгжүүлнэ.	Дата төвийн кибер аюулгүй байдлын уян хатан байдлыг сайжруулж, халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадамжийг бүрдүүлэх	халдлагад хариу үйлдэл үзүүлэх тайлангаар	1	2	Улсын төсөв
	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний болон мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх, хэрэгжилтийг хангах, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвд тайлагнах	Аудит, эрсдэлийн үнэлгээгээр	2	4	Улсын төсөв
	Кибер халдлага, зөрчлийн талаар гадаад болон Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага солилцох	Хамтын ажиллагаа туршлага нэвтрүүлсэн байдал	0	1	Улсын төсөв
	Кибер аюулгүй байдлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зүй, зөвлөгөөг хэрэглэгч, байгууллагуудад түгээх	Өгсөн зөвлөмж, мэдээллийн тоогоор	10	100	Улсын төсөв
	Халдлагад хариу үйлдэл үзүүлэх, байгууллагын болон үйлчилгээ авч буй байгууллагуудад дэмжлэг үзүүлэх	Хамтран ажилласан байдал	1	2	Улсын төсөв
Үндсэн чиг үүрэг 5: Интернетийн дотоод харилцан холболтын ашиглалт, үйлчилгээг хариуцах, харилцан холболтын төхөөрөмжөөр дамжиж буй халдлага, будилааны талаар анхааруулга өгөх					
Зорилт-3. Нийтийн мэдээллийн сан, дэд бүтцийн хэвийн, тасралтгүй, аюулгүй	Мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний үйлдлийн бүртгэлийг кибер аюулгүй байдлын нийтлэг журамд заасан хугацаанд хадгалах	Хадгалалтын байдлаар	1	1	Улсын төсөв

байдлыг хангасан шинэчлэлийг хэрэгжүүлнэ.	Интернэтийн дотоод харилцан холболтын төхөөрөмжөөр дамжиж буй халдлага будилааны талаар анхааруулга өгөх	Төлөвлөгөөний тоо	0	1	Улсын төсөв
	Монголын интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх	Харилцан холболт тасралтгүй байх нөхцөлөөр	1	1	Улсын төсөв
	Интернэтийн дотоод харилцан холболтыг сайжруулах, аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах	Харилцан холболтын сайжруулалт	1	2	Улсын төсөв
Үндсэн чиг үүрэг 6: Нийтийн мэдээллийн бүтцийн хүрээнд төрийн болон бусад байгууллагад үйлчилгээ үзүүлэх, захиргаа удирдлагаар хангах					
Зорилт-4. Нийтийн мэдээллийн дэд бүтцэд суурилсан үйлчилгээг хүний нөөцийн тогтвортой хөгжил, удирдлага зохион байгуулалтын хүрээнд үзүүлнэ.	Төрийн болон бусад байгууллагад мэдээлэл солилцооны үйлчилгээ үзүүлэх	Мэдээлэл солилцох нөхцөл бүрдсэн байна.	1	1	Улсын төсөв
	Мэдээллийн технологид суурилсан үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх замаар төрийн цахимжилтад дэмжлэг үзүүлж, хэрэглэгчийн үйлчилгээний сэтгэл ханамжийг дээшлүүлэх	Хэрэглэгчийн судалгааны үр дүнгээр	0	1	Улсын төсөв
	Үйлчилгээний системийг автоматжуулж, тоон гарын үсгийн хэрэглээнд тулгуурласан цаасгүй технологийг нэвтрүүлэх	Үйлчилгээний автоматжуулсан систем нэвтэрсэн эсэх	0	1	Улсын төсөв
	Байгууллагын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 Олон улсын стандарт нэвтрүүлэх, хэрэгжүүлэх	Стандартын баталгаажуулалт, сайжруулалт хийгдэж буй эсэх	0	1	Улсын төсөв

	Олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж, сайн туршлагыг нэвтрүүлэх	Хамтын ажиллагааны хэрэгжилт	1	2	Улсын төсөв
	Байгууллагын стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх, дүгнүүлэх	Төлөвлөгөөний тоо	0	2	Улсын төсөв
	Дотоод үйл ажиллагаа болон газар, хэлтсийн уялдаа холбоог сайжруулах	Уялдаа холбоотой ажиллах нөхцөл бүрдсэн эсэх	1	1	Улсын төсөв
	Байгууллагад мөрдөгдөх дотоод журам, заавар, дэг боловсруулах, шинэчлэн сайжруулах, хэрэгжилтийг хангуулах	Журам, зааврын тоо	46	50	Улсын төсөв
	Албан хаагчдыг мэргэшүүлэх, сургалтад хамруулах, нийгмийн баталгааг нь хангах	Сургалтын тоо + Нийгмийн баталгааг хангах арга хэмжээний тоо	10 + 0	30 + 4	Улсын төсөв
	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх	Хэрэгжилт, төлөвлөлтийн тоо	1	5	Улсын төсөв

**НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ**



Зураг. Стратегийн төлөвлөгөө ба байгууллагын бүтцийн уялдаа

ЕС. ХАВСРАЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль,
2. Хөдөлмөрийн тухай хууль,
3. Харилцаа холбооны тухай хууль,
4. Цахим гарын үсгийн тухай хууль,
5. Кибер аюулгүй байдлын тухай хууль,
6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль,
7. Улсын бүртгэлийн ерөнхий хууль,
8. Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,
9. Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа,
10. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 13 дугаар тогтоолын хавсралт “Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”,
11. “Мэдээллийн аюулгүй байдлын ISO:27001”, “Чанарын менежментийн тогтолцоо ISO:9001” стандарт,
12. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/34 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм”,
13. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/24 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим Үндэстэн” баримтлах чиглэл,
14. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2013-2016 оны стратегийн төлөвлөгөө,
15. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө,
16. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2022 оны гүйцэтгэлийн тайлан,
17. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө,
18. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2023 оны гүйцэтгэлийн тайлан,
19. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө.